



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 12 сарын 09 өдөр

Дугаар А/А66

Булган сум

**Дотоодын худалдан авалтаар дэмжих
уриалга гаргах тухай**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Жижиг, дунд үйлдвэр үйлчилгээг дэмжих тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2 дахь хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны хуралдааны IV/25 дугаар тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2024-2028 онд хэрэгжүүлэх “Булганы сэргэлт үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 21.4.1 дэх заалт, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 78 дугаар тогтоолоор батлагдсан “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Булганы сэргэлт” үйл ажиллагааны хөтөлбөр, “Үйлдвэрлэлийн сэргэлт” хөтөлбөрт тусгагдсан үйлдвэрлэлийг хөгжүүлж, үйлчилгээг сайжруулан ажлын байрыг нэмэгдүүлэх, орон нутгийн үйлдвэрлэгч иргэн, аж ахуйн нэгж, хоршоодын борлуулалтын орлогыг нэмэгдүүлж, чадавхжуулах, кластерийг хөгжүүлэхэд худалдан авалтаар дэмжлэг үзүүлэхийг иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагч, үйлдвэрлэгчдэд тус тус уриалсугай.

2. Төсвийн байгууллагын байнгын хэрэгцээтэй бараа, ажил үйлчилгээг орон нутгийн хоршоо, үйлдвэрлэл, худалдаа үйлчилгээ эрхлэгчдээс худалдан авах үйл ажиллагааг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн зохион байгуулж, дэмжиж ажиллахыг бүх шатны төсвийн шууд захирагч нар, сумдын Засаг дарга нарт даалгасугай.

3. Төсвийн байгууллагын худалдан авах ажиллагааг зохион байгуулдаг албан хаагчдыг сургалт арга зүйгээр ханган чадавхжуулж, үндэсний болон орон нутгийн үйлдвэрлэл үйлчилгээ эрхлэгчид, хоршоодыг дэмжих төрийн бодлогын талаарх мэдлэгийг дээшлүүлэхэд хамтран ажиллахыг Худалдан авах ажиллагааны газар (Б.Баярцэнгэл), Хүнс, хөдөө аж ахуйн газар (Н.Пүрэвсайхан), заавал баталгаажуулах шаардлагатай бүтээгдэхүүн үйлчилгээг стандартад нийцүүлэхийг Стандарт, хэмжил зүйн хэлтэс (Д.Алтаншагай)-т тус тус даалгасугай.

4. Дотоодын худалдан авалтын мэдээг нэгтгэж сар бүрийн 25-ны дотор танилцуулж, тайлагнаж байхыг Статистикийн хэлтэс (М.Мөнхбат)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР



СЗ25011164